

22. Их Эзэн Минь Ээ, Хүчирхэг удирдагчдыг Сири, Иордан дахь биеэ үнэлэлтийг зогсоохыг уриалаач. Мөн урхинд орсон өсвөр насны охидод танд ямар их үнэ цэнтэй хайртайг гэдгийг олж мэдэхэд нь туслаарай. (Еф. 3:17–19)

23. Бурхан Эзэн Минь Ээ, Өмнөд Суданы Арабын эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалж, хямралын үед гэр бүлийнхээ эмнэлгийн хэрэгцээг хангахад нь туслах хүчийг өгөөч. Мөн эрүүл мэндийн үйлчилгээг илүү сайн авах боломжийг олгох болтугай. (Дуу. 102:2–3)

24. Тэнгэрлэг Эцэг минь ээ, Арабын орнуудад амьдардаг өрх толгойлсон эхчүүдэд хэчнээн их хайртай, тэднийг хүлээн зөвшөөрч байгаагаа харуулаач. Тэд танаас үнэ цэнэ, дэмжлэгийг олох болтугай. (Матай 10:31)

25. Аав аа, засгийн газрын дарамтад байгаа Ойрхи Дорнодын бүх сүмийн удирдагчдыг хамгаалаач. Эдгээр удирдагчдад таны оршихуйг өдөр бүр мэдэрч, шүүхийг нааштай шийдвэр гаргахад нь туслахыг бид танаас хүсэж байна. (Иохан 15:18)

26. Эзэн минь, дайны улмаас хүүхдүүдээ алдаж буй Палестин эмэгтэйчүүдийг тайвшруулаарай. Тэд таны амар амгаланг мэдрэхийн тулд тэдэнд Аврагч Бурхан гэдгээ харуулаарай. (Иохан 16:33)

27. Арабын орнуудын дунд сайн мэдээ хамгийн бага хүртээмжтэй хүрдэг бүлгүүдийн нэг нь Ливийн эмэгтэйчүүд юм. Тэнгэрлэг Эцэг минь, эдгээр эмэгтэйчүүдэд таны итгэл найдвар сонсогдох болтугай. (Кол. 4:3)

28. Ойрх Дорнодын олон эмэгтэйчүүд Христийг хүлээн зөвшөөрсөн учраас гэр бүлээсээ гадуурхагддаг. Эзэн минь, тэдний зүрх сэтгэлийг Өөрийн хайр, нигүүлслээр дүүргээч. (1 Иохан 3:1)

29. Мароккогийн эмэгтэйчүүдийн дунд ургац арвин байна гэж бид Таныг магтъя, Эзэн минь. Эдгээр эмэгтэйчүүдэд үйлчилж, Христэд итгэгч нөхөрлөлийг санал болгож чадах удирдагчдыг олоход манай багийг удирдан чиглүүлээч. (Лук 10:2)

30. Бурхан минь, Арабын залгамжлагч бүлгүүд хоол хүнс, санхүүгийн тусламж хүссэн олон хүсэлтийг шийдвэрлэхэд мэргэн ухаан, хангамжийг өгөөч. (Матай 7:11)



**Найдвартай
эмэгтэйчүүд**

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанли
100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа
залбирч байна.



2022. 09.

**Дундад Ази, ойрхи дорнод, хойд Африк
эмэгтэйчүүдийн төлөөх залбирал.**

Ислам гэдэг үг нь 'Дуулгавар' гэсэн утгатай. Энэ нь Аллад бүрэн дуулгавартай байхыг шаарддаг. Мөн 'Амар амгалан' гэсэн утгатай төдийгүй Аллад л дуулгавартай байвал жинхэнэ амар амгаланг эдлэнэ гэж ярьдаг. Зөвхөн Есүс л Аврагч гэдгийг мэдэх хүртэл нь, Христэд итгэгчид амьдралаараа сайн мэдээг дамжуулахын төлөө залбирцгаая.

TWR Women of Hope

<https://www.twrwomenofhope.org>

E-mail: phkorea@twrk.or.kr

1. Төгс Хүчит Бурхан минь ээ, Саудын Арабын “Найдвар доторх Эмэгтэйчүүд” төслийн багийнхны итгэл найдварыг дүүрэн байлгаж, баяр хөөртэйгөөр үйлчлэлээ үргэлжлүүлэн хүргэхийн тулд хүсэл тэмүүлэл, тэсвэр тэвчээрийг өгөөч. (2 Тес. 3:13).

2. Ойрх Дорнодын улсуудад инфляци өссөнөөс болж түрээс, хүнсний үнэ хоёр дахин нэмэгдсэн тул хүүхэдтэй ганц бие эмэгтэйчүүд зайлшгүй шаардлагатай зардлаа төлж чадахгүй байна. Эзэн минь, эдгээр эмэгтэйчүүд, хүүхдүүдэд анхаарал халамж тавьж өгөөч. (Филиппой 4:19)

3. Эзэн минь, Ливаны эмэгтэйчүүд, хүүхдүүд эдийн засгийн нөхцөл байдалд улам бүр бухимдаж буй эрчүүдийн хүчирхийлэлд өртөж байгаад та харамсаж байгааг бид мэдэж байна. Тэднийг хамгаалаарай. (Дуу. 9:9)

4. Аав аа, Саудын Арабын христийн шашинтай эмэгтэйчүүдэд итгэл үнэмшлээ баталж чадахгүй хязгаарлагдмал нийгэмд амьдарч байна. Тэдэнд амар амгалан, мэргэн ухааныг болон эрх чөлөөг өгөөч. (Дуу. 117:6).

5. Эзэн минь, Ойрх Дорнодоос дүрвэсэн гэр бүлүүд бусад улс орнуудад очиж цагаачлан амьдрахад нь тэднийг урамшуулж, итгэл найдвараа харуулаач. (Дэд хууль 10:19)

6. Аав аа, 11 жил дүрвэгсдийн хуаранд амьдарч буй Сири эмэгтэйчүүдтэй холбоо бариарай; Танд хандан итгэл найдвараа олоход нь туслахын тулд “Найдвар доторх Эмэгтэйчүүдийг” ашиглаач. (Ром. 15:13)

7. Ойрх Дорнодод бага цалинтай, гэр бүлээсээ тусламж авдаггүй бэлэвсэн эмэгтэйчүүдийг Бурхан та халамжлаач. Эдгээр эмэгтэйчүүдэд хүчийг өгөөч. (Исаиа 41:10).

8. Аав аа, Ойрх Дорнодын хүнд өвчтэй хүмүүсийг хүч чадлаараа эдгээж, оюун санааны болон бие махбодын сэргээгээч, учир нь тэд эмийн инфляци өсөх тусам шаардлагатай эмээ авч чадахгүй байхвий гэхээс маш их айж байна. (Иер. 17:14).

9. Ойрх Дорнодод жил бүр таван мянган эмэгтэй бэлгийн хүчирхийллийн золиос болсон ч “нэр төрийнхөө төлөө” алагддаг. Бурхан минь, энэ харгислалыг таслан зогсоохын тулд соёлын өөрчлөлтийг авчраач. (1 Тим. 2:1–2)

10. Эзэн минь, Саудын Араб дахь Христийн шашны гэрлэлтийг бэхжүүлээч. Эрэгтэйчүүдийг уруу таталтыг эсэргүүцэж, гэр бүл, сүмдээ хүчирхэг, бурханлаг удирдагч байхад урамшуулаач. (1 Тим. 3:2–5)

11. Эзэн минь, төөрсөн, ганцаардмал эмэгтэйчүүдэд таны сайн мэдээг хэрхэн хүргэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах манай Арабын яамны багт бүтээлч сэтгэлгээг өгөөч. (Марк 16:15)

12. Төгс Хүчит Бурхан минь ээ, ажилгүйдэл, ядууралд нэрвэгдсэн Тунисын хөдөөгийн эмэгтэйчүүдэд туслаач. Эрх мэдэлтэй албан тушаалтнуудад асуудлын үр дүнтэй шийдлийг олох мэргэн ухааныг өгөөч. (Дуу. 69:10).

13. Бурхан минь, шоронд хоригдож буй Ойрх Дорнодын эмэгтэйчүүдийг Христ болон түүний эрх чөлөөг олоход чиглүүлээч. Тэдэнд өөрийнхөө жинхэнэ дүр төрхийг олоход нь туслаач. (Иохан 8:32)

14. Аав аа, Ойрх Дорнодын эмэгтэйчүүд болон та хоёрын хооронд шинэлэг бөгөөд гүн гүнзгий харилцаа бий болох болтугай. Хамтран ажиллагсад маань үйлсийнхээ үр шимийг харж, мэргэн ухаан, өршөөл нигүүлслээр тэднийг урамшуулаарай. (Гал. 6:9)

15. Эзэн минь, Ойрх Дорнодын орнуудаас албадан хөөгдсөн гэр бүлүүдэд үйлчилдэг шинэ сүмүүдийг хамгаалаач. Тэдэнд сайн мэдээг үр дүнтэй хуваалцахад тусалж мэргэн ухааныг өгөөрэй. (Лук 9:6)

16. Бурхан минь, бид тодорхой соёлын итгэл үнэмшлээсээ болж хүчирхийлэлд өртөж буй Йемен эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Сүмийн бусад гишүүдийг Христ дотор олсон эрх чөлөөнийхөө талаар бусдад хэлэхийг уриалаач. (2 Коринт 3:17)

17. Тэнгэрлэг Эцэг минь, Ирак дахь эрчүүдийг хүйсийн тэгш байдлын төлөө тэмцэгч болгон өргөөч. Шударга хөдөлмөр эрхлэлтийг хангах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах өөрчлөлтийг хийгээч. (Сургаалт үгс 31:8-9)

18. Олон хязгаарлалтын дараа TWR байгууллагын “Найдвар доторх Эмэгтэйчүүд”социал медиа платформ дээр Саудын Арабд дахин нээгдсэнд Бурхан минь, Танд баярлалаа. Тэднийг хамгаалж байгаарай. (2 Тесалоник 3:3).

19. Аав аа, тэд танд ямар чухал болохыг сонссон Алжир, Марокко эмэгтэйчүүдэд баярлалаа. Тэднийг улам бүр танруу хандах сонирхлыг бий болгож, амьдралыг нь өөрчлөөч. (Дуу. 63:1).

20. Аав аа, Ойрх Дорнод дахь TWR-ийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд” ажилтнуудад Христ доторх хайрын жинхэнэ утгыг дамжуулахад үр дүнтэй элчин сайд болоход туслаарай. (Ром. 5:8).

21. Төгс Хүчит Бурхан минь ээ, хүчирхийлэлд өртсөн Ойрх Дорнодын бүх дүрвэгсдийг суллаач. Тэдэнд танаас ирдэг итгэл найдвар, эрх чөлөөг өгөөч. (Дуу. 117:5).